



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

УСНЫ ГАЗАР

Чингүнжавын гудамж, 2 дугаар хороо,
Баянгол дүүрэг, Улаанбаатар хот, 16050
Утас/Факс: (976-51) 26 55 78, (976-51) 26 55 36,
Цахим шуудан: office@water.gov.mn,
Цахим хуудас: www.water.gov.mn

2026.01.02 № 01/1
танай _____-ны № _____-т

Тайлан хүргүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт хавсралтаар батлагдсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын дагуу Усны газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд болон төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтэд тус тус үнэлгээ хийж тайланг хавсралтаар хүргүүлж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 183 дугаар тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих нийтлэн журам”-ын дагуу Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг Байгаль орчин, уур амьсгалын өөрлөлтийн яамд хүргүүлсэн болно.

Хавсралт: 32 хуудастай.

Ирээдүй хойч үедээ усны нөөцөө үлдээхийн төлөө усаа хамгаалъя,
хуримтлуулъя, хамтран ажиллая!

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



З.БАТБАЯР

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ УСНЫ ГАЗРЫН
2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2025.12.18

Улаанбаатар хот

**Нэг. Танилцуулга, үнэлгээний зорилго, үндэслэл,
үнэлгээний арга, аргачлал**

Усны газрын хэрэгжүүлж буй бодлого нь усны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, ус ашиглалт болон бохирдлын зохицуулалтыг сайжруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний зорилгыг хангахад чиглэж байна. Энэхүү бодлого нь Усны тухай хууль, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль болон салбарын бусад бодлогын баримт бичгүүдтэй уялдсан бөгөөд төрөөс усны салбарт баримталж буй стратегийн зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн.

Үнэлгээ хийх үндэслэл, ач холбогдол: Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын дагуу төрийн бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг бодитой үнэлэх, үр дүн, нөлөөллийг тодорхойлох, цаашдын бодлогын шийдвэрийг нотолгоонд суурилан гаргахад чиглэсэн.

Энэхүү үнэлгээгээр байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн бодит түвшинг тогтоох, үр дүнд суурилсан удирдлагыг бэхжүүлэх, төсөв, нөөцийн үр ашигтай ашиглалтыг дэмжих, цаашдын бодлого, төлөвлөлтөд шаардлагатай санал, зөвлөмж боловсруулсан нөхцөл байдлыг тодорхойлсон болно.

Үнэлгээ нь холбогдох хууль тогтоомж, журам, аргачлалд тулгуурлан баримт бичгийн шинжилгээ, тоон мэдээлэл, тайлагналын дүн шинжилгээний аргыг ашигласан. Үүнд:

- **Баримт бичгийн шинжилгээ:** Жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан, холбогдох хууль, журам, тогтоол, сайдын тушаал, дотоод тайлагналын материалд дүн шинжилгээ хийсэн

- **Шалгуурт суурилсан үнэлгээ:** Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан хяналт-шинжилгээ, үнэлгээний журам, шалгуур үзүүлэлтүүдтэй тулган үнэлсэн

- **Үнэлгээний аргачлал:** Арга хэмжээ бүрийг хэрэгжилтийн хувь, чанар, нотолгоонд үндэслэн зорилтод түвшинд хүсэн байдлаар үнэлсэн, Хэрвээ зорилтод түвшинд хүрээгүй бол хэрэгжүүлсэн ажлыг тухайн зорилтод түвшинд хамаарах хэсгийн хэдэн хувийн гүйцэтгэлийн хувийн жинг агуулж байгаагаар нь тодорхойлж, тэдгээрийн гүйцэтгэлийг хувилан нэмэх байдлаар тооцоолж буюу төлөвлөсөн зорилт, гүйцэтгэл, тайлагналын уялдаа холбоог харьцуулан дүгнэсэн. Тухайлбал: Усны газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлэх хамгийн эхний арга хэмжээ:

Арга хэмжээ 1.1: Гидрогеологийн дунд масштабын (1:200000) зураглалын ажлыг өргөжүүлж, усны нөөцийн тархалтыг тогтоох

Төсөв: 800,0 сая Улсын төсөв

Арга хэмжээний шалгуур үзүүлэлт: Гидрогеологийн дунд масштабын зураглал хийсэн газар нутгийн хэмжээ, хувь

Суурь түвшин: 17.8 хувь

Зорилтод түвшин: 18.8 хувь

Хүрсэн түвшин /тайлан/: Гидрогеологийн дунд масштабын зураглал хийх ажлын даалгаврыг боловсруулж, 2025.05.14-ний өдөр батлуулсан. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж байна. Худалдан авах ажлыг нээлттэй сонгон шалгаруулах зарыг tender.gov.mn цахим хуудсаар 2025.05.21-ний өдөр нийтэлсэн бөгөөд 2025.06.12-ны өдөр нээж, шаардлага хангасан хүсэлт ирээгүй тул амжилтгүй болсон.

Гидрогеологийн дунд масштабын зураглал хийх ажлыг tender.gov.mn цахим хуудсаар 2025.06.30-ны өдөр дахин нийтэлсэн бөгөөд 2025.07.22-ны өдөр нээж, дахин амжилтгүй болсон.

2025 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн. Үүнтэй холбогдуулан "Төсвийн зардлын хуваарьт өөрчлөлт оруулж, эрх шилжүүлэх тухай" Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны А/275 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Усны нөөц, нуур, гол мөрний менежмент хөтөлбөрийн зардлын хуваарь"-ийн 2 дахь үйл ажиллагаанд тусгагдсан зураглалын ажлын төсөв хасагдаж батлагдсан тул ажлыг гүйцэтгэх боломжгүй болсон.

Гүйцэтгэлийн хувь: 58 хувь.

Үнэлгээний үндэслэл, арга, аргачлал: Тухайн арга хэмжээ нь Усны газраас үл хамаарах шалтгаанаар төсөв татагдсантай холбоотойгоор гүйцэтгэл хойшилсон байна. Үүнтэй холбоотойгоор тухай арга хэмжээний үнэлгээг өгөхдөө Зорилтод түвшинд хүрээгүй тул дээр дурдсан арга, аргачлалаар буюу хэрэгжүүлсэн ажлыг тухайн зорилтод түвшинд хамаарах хэсгийн хэдэн хувийн гүйцэтгэлийн хувийн жинг агуулж байгаагаар нь тодорхойлж, тэдгээрийн гүйцэтгэлийг хувилан нэмэх байдлаар тооцоолоход а/Төлөвлөлтийн ажил нийт ажлын 30 хувь, б/Худалдан авах ажиллагаа зарлах, сонгон шалгаруулж гэрээ байгуулах ажил нийт ажлын 40 хувь, в/Ажлыг гүйцэтгэлийг нийт ажлын 30 хувь байхаар тооцож үнэлгээ өгөхөд

1.Төлөвлөлтийн ажил буюу ажлын даалгаврыг боловсруулж, хугацаанд нь батлуулсан байдлыг нийт ажлын 30 хувиас 100 хувь хэрэгжүүлсэн тул = 30 хувь.

2. Худалдан авах ажиллагаа зарлах, сонгон шалгаруулж гэрээ байгуулах ажил нь төрийн худалдан авах ажиллагааны дагуу хоёр удаа нээлттэй тендер зарласан, процедурын хувьд бүрэн биелсэн боловч тендерүүд амжилтгүй болсон байна. Иймд тодорхой ажил хийгдсэн тул 70 хувийн гүйцэтгэлтэй гэж үзээд энэ ажил нь нийт ажлын 40 хувийг хамаарах тул 40-ийн 70 хувь нь = 28 хувийг хэрэгжүүлсэн.

3.Ажлын гүйцэтгэл буюу гидрогеологийн дунд масштабын зураглалын ажил нь санхүүжилт хасагдсанаар бодит зураглалын ажил хийгдээгүй тул 0 хувийн гүйцэтгэлтэй тул=0 хувь болно.

Иймд $30+28+0=58$ хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлсэн. Өөрөөр хэлбэл санхүүжилт шийдвэрлэгдсэн тохиолдолд тухайн ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэхэд 58 хувийн ажлын бэлтгэл ажил хангагдсан байна гэж үзлээ.

Үнэлгээ хийх явцад зарим арга хэмжээний хэрэгжилтийг нотлох тоон өгөгдөл дутмаг, тайлагнал нь ихэвчлэн хийсэн ажилд төвлөрөн бичигдсэн боловч дээрх арга, аргачлалын дагуу дүгнэлтийг боломжит бодит өгөгдөл, нотолгоонд суурилан боловсруулсан болно.

Хоёр: Үнэлгээний дүгнэлт

Усны газрын 2025 онд хэрэгжүүлсэн бодлого, үйл ажиллагаа нь усны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, ус ашиглалт болон бохирдлын зохицуулалтыг сайжруулах үндсэн зорилгыг тодорхой түвшинд хангаж, салбарын өдөр тутмын үйл ажиллагааны тасралтгүй байдлыг бүрэн хангаж ажилласан байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр бодлогын хэрэгжилт нь үйл ажиллагааны гүйцэтгэлийн түвшинд хангалттай, харин үр дүн нөлөөллийн түвшинд хязгаарлагдмал гэж дүгнэгдэв.

Бодлогын ололт амжилтын хувь

1. Ус ашиглуулах боломжит нөөцийн хэмжээг тогтоох, ус ашиглуулах болон хаягдал ус хаях, зайлуулах дүгнэлт, ус бохирдуулсны төлбөрийн тогтолцоо гаргах зэрэг үндсэн үйл ажиллагааг тасралтгүй хэрэгжүүлж дээд шатанд буюу цахимаар дүгнэлт гаргадаг болсон.

2. Усны тухай хууль, холбогдох журам, аргачлалын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, сайжруулах санал боловсруулах ажлын хэсэг байгуулагдаж, хуулийн төслийг бэлтгэсэн байна.

3. Байгууллагын ажлын тайлагналын тогтолцоог сайжруулах эхлэл тавигдсан буюу чадавхын ахиц сайжирсан байна.

4. Салбар хоорондын уялдааг хангах, олон улсын байгууллагуудын хамтын ажиллагаа тодорхой чиглэлд сайжирсан.

5. Байгууллагын бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийж ажлын уялдаа холбоог нягтруулан, бүтээмжийг нэмэгдүүлэх шийдвэр гаргасан байна.

Бодлогын дутагдал ба шийдвэрлэх шаардлагатай асуудал

1. Ажлын тайлагнал нь ихэвчлэн хийсэн ажилд төвлөрөн бичигдсэн, бодлогын бодит өөрчлөлтийг илэрхийлэх үзүүлэлт дутмаг байна.
2. Санхүү үр ашгийн уялдаа сул буюу зардал, үр өгөөжийн шинжилгээ тогтмол хийгдээгүй байна.
3. Байгууллагын үйл ажиллагааны тоон мэдээллийн бүрдэлт буюу нэгдсэн сан бүрэн төлөвшөөгүй байна гэж үзлээ.

Усны газраас 2025 онд 19 зорилтын хүрээнд 70 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн, шалгуур үзүүлэлтийн дагуу зорилт, арга хэмжээ тус бүрээр хүрсэн түвшин, суурь түвшин, зорилтод түвшинг аргачлалын дагуу хувиар илэрхийлж үнэлгээ хийхэд 94,3 хувьтай үнэлэгдэв. Төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээг хүснэгтээр харуулав.

д/д	Зорилт, арга хэмжээ	Бүгд	Үнэлгээ					Хэрэгжилт
			95-100 хүртэл	90-95 хүртэл	85-90 хүртэл	70-85 хүртэл	59 хүртэл	
Үнэлгээ	Бүрэн хангалттай: 85 -100 хувь	61	51	7	3	-	-	87.1%
	Хангалттай: 70-85 хувь	5	-	-	-	5		7.1%
	Хангалтгүй: 70 хүртэл хувь	4	-	-	-	-	4	5.7%
НИЙТ		70	94.3 хувь					

Гүйцэтгэлийн тайлангийн арга хэмжээ бүрд өгсөн үнэлгээг тайлбарын хамт хавсаргав.

Усны газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дараах зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

1. Гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө, санхүүг бүрэн тусгаагүйгээс хэрэгжилт хангалтгүй байгаа тул хөрөнгийг оновчтой төлөвлөж, төсөвт тусгаж, дэвшүүлсэн зорилго, зорилтуудын хэрэгжилтийг хангаж ажиллах.
2. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнахдаа тухайн арга хэмжээний биелэлтэд хамаарах хэрэгжилтийн үр дүнг нэгтгэж бүрэн тайлагнахыг албан хаагчид анхаарч ажиллах.
3. Санхүүжилтийн эх үүсвэр нь шийдэгдээгүй, хэрэгжүүлэх эсэх нь тодорхой бус арга хэмжээнүүдийг анхааралдаа авч, хөрөнгийн эх үүсвэрийг нарийвчлан судалж, хэрэгжүүлэх, цаашид бүрэн хэрэгжихүйц төлөвлөлт хийх.

4. Хангалтгүй болон хангалттай /зорилтот түвшинд бүрэн хүрээгүй, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах/ үнэлгээний ангилалд хамаарч байгаа арга хэмжээнүүд нь тухайн ажлыг хариуцсан албан хаагчийн үйл ажиллагаанаас шалтгаалсан бол хариуцлага тооцох.
5. Төрийн албан хаагчид зөв, оновчтой, шуурхай тайлагнаж суралцах, баримт бичиг боловсруулах ур чадварыг дээшлүүлэх, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг судалгаа, нотолгоо, баримтад тулгуурлан үнэн зөв 2000 тэмдэгтэд багтааж тайлагнаж, нэгжийн дарга нар бүх түвшинд ажлын гүйцэтгэлд хяналт тавих, мэргэжил аргазүйн зөвлөгөө, өгч дотоод хяналтыг сайжруулах.

ТАНИЛЦСАН:

УСНЫ ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

З.БАТБАЯР

ХЯНАСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.САЙХАНЖАРГАЛ

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХУУЛЬ ТОГТООМЖ, ХАМТЫН АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Д.ЖАРГАЛ

УСНЫ ГАЗРЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭГТЭЛИЙН ТАЙЛАНГИЙН ҮНЭЛТЭЭ

А/д	Стратегик төлөвлөгөө болон үндэслэл байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв		Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилготой түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэтгэл ийн хууь
		Хэмжээ, сая төг	Төсвийн эх үүсвэр					
УСНЫ ГАЗРЫН СТРАТЕГИЙН ЭРХЭМ ЗОРИЛГО: Усны талаарх хууль тогтоомж, бодлого хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, усны нөөцийн нэгдсэн менежментийн зарчмыг хэрэгжүүлэх, мэргэжил аргагүйн удирдлагаар хангах хангах, усны хэмнэлттэй, үр ашгтай хэрэглээг төлөвшүүлэхэд чиглэдэг.								
НАГДУУЗАР ХЭСЭГ: БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАЛДСАН БОЛОН ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ (Алсын хараа 2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилт 6.3, 9.2, Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн Зорилт 6.3, Монгол улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Зорилт 1.3.1.2, 3.4.2.1, 3.4.2.3, 3.4.2.5, 3.4.2.7, Монгол улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний Зорилт 1.11.3/)								
Үйл ажиллагааны 1 дүгээр зорилт: Усны нөөцийг судалж тогтоох, усны нөөц, түүний сав газрыг хамгаалах, нөхөн сэргээх, үер уснаас хамгаалах, усны нөөцийг хуримтлуулах, нөхөн сэргээх, ариунжуулах, усны нөөцийн эрэлт, нийлүүлэлтийг зохицуулах, усны нөөцийг тулгуурласан төлөвлөлтийг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлж, хяналт тавих, усны сав газрын менежментийн тогтолцоог бэхжүүлэх. БОАЖ сайдын 2024 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн А/49 дугаар тушаалаар батлагдсан Усны газрын үйл ажиллагааны стратегийг, усны сав газрын удирдлагын бичиг, усны нөөцийн хөтөлбөрийн стратегийг зорилт 2.4.1/								
1	Арга хэмжээ 1.1. Гидрогеологийн дүнд мөшлөхөн (1:200000) зураглах ажлыг өргөжүүлж, усны нөөцийн тархалтыг тогтоох	1,957.2	Төсвийн тусгай эх үүсвэр	Арга хэмжээний мөшлөхөн дүнд гүйцэтгэлийн хууь	Гидрогеологийн дүнд мөшлөхөн дүнд гүйцэтгэлийн хууь 17.8%	Хайгуулын судалгааны ажлын явцад хяналт тавих, мэргэжил аргагүйн зөвлөмж өгч, судалгааны тайланг хүлээн авч, усны нөөцийн зөвлөлд, хүргүүлсэн байна	Зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд нийт 5 арга хэмжээ талархан хэрэгжүүлэхээр зорилтын гол зорилт хүрэх түвшин болох усны нөөцийг хайгуул судалгааны ажлын явцад хяналт тавих, мэргэжил аргагүйн зөвлөмж өгч, судалгааны тайланг хүлээн авч, усны нөөцийн зөвлөлд, хүргүүлсэн байх зорилтын дүндээ гүйцэтгэлтэй байна	Дүндээ үнэлгээ 84.6
		800.0	Улсын төсөв	Гидрогеологийн дүнд мөшлөхөн дүнд гүйцэтгэлийн хууь хэмжээ хууь	17.8%	Гидрогеологийн дүнд мөшлөхөн дүнд гүйцэтгэлийн хууь хэмжээ хууь	Гидрогеологийн дүнд мөшлөхөн дүнд гүйцэтгэлийн хууь хэмжээ хууь	58
		2025 оны Төсвийн тусгай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн. Үүнтэй холбоотойгоор Төсвийн зардлын хуваарьт өөрчлөлт оруулж ажил хийгдсэн тул 70% гүйцэтгэлтэй гэж үзэвч энэ ажил нь нийт ажлын 40%-ыг хангаварх тул 40-ийн 70 хууь нь = 28%						
2	Арга хэмжээ 1.2 "Шинэ хархорум" хотын хүн амын үнд, ахуйн эх үүсвэрийг тогтоох газрын доорх усны эрэл, хайгуулын судалгааны ажлыг зохион байгуулахад мэргэжил арга зүйн зөвлөмж өгч амилгах	Зөвлөмжийн тоо	Зөвлөмжийн тоо	Шинэ хархорум" хотын хүн амын үнд, ахуйн эх үүсвэрийг тогтоох газрын доорх усны эрэл, хайгуулын судалгааны ажлыг зохион байгуулахад мэргэжил арга зүйн зөвлөмж өгч амилгах	Шинэ хархорум" хотын хүн амын үнд, ахуйн эх үүсвэрийг тогтоох газрын доорх усны эрэл, хайгуулын судалгааны ажлыг зохион байгуулахад мэргэжил арга зүйн зөвлөмж өгч амилгах	Шинэ хархорум" хотын хүн амын үнд, ахуйн эх үүсвэрийг тогтоох газрын доорх усны эрэл, хайгуулын судалгааны ажлыг зохион байгуулахад мэргэжил арга зүйн зөвлөмж өгч амилгах	Шинэ хархорум" хотын хүн амын үнд, ахуйн эх үүсвэрийг тогтоох газрын доорх усны эрэл, хайгуулын судалгааны ажлыг зохион байгуулахад мэргэжил арга зүйн зөвлөмж өгч амилгах	100
3	Арга хэмжээ 1.3 Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дахь Гүний хоолойн газрын доорх усны ордны ашиглалтын судалгааны ажлыг гүйцэтгэлд, 1:30 доошгүй хайгуулын судалгааны ажлын гүйцэтгэлд тусгаж, нөөцийн тайланг хяналт тавих.	Хяналтын тоо	Хяналтын тоо	Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дахь Гүний хоолойн газрын доорх усны ордны ашиглалтын судалгааны ажлыг гүйцэтгэлд, 1:30 доошгүй хайгуулын судалгааны ажлын гүйцэтгэлд тусгаж, нөөцийн тайланг хяналт тавих.	Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дахь Гүний хоолойн газрын доорх усны ордны ашиглалтын судалгааны ажлыг гүйцэтгэлд, 1:30 доошгүй хайгуулын судалгааны ажлын гүйцэтгэлд тусгаж, нөөцийн тайланг хяналт тавих.	Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дахь Гүний хоолойн газрын доорх усны ордны ашиглалтын судалгааны ажлыг гүйцэтгэлд, 1:30 доошгүй хайгуулын судалгааны ажлын гүйцэтгэлд тусгаж, нөөцийн тайланг хяналт тавих.	Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дахь Гүний хоолойн газрын доорх усны ордны ашиглалтын судалгааны ажлыг гүйцэтгэлд, 1:30 доошгүй хайгуулын судалгааны ажлын гүйцэтгэлд тусгаж, нөөцийн тайланг хяналт тавих.	95

1. Төлөвлөлийн ажил: Ажлын даалгаврыг боловсруулж, хугацаанд нь батлуулсан тул бүрэн биелсэн бөгөөд нийт ажлын 30%

2. Хуваагдсан ажил: Төрийн хуваагдсан ажиллагааны дагуу хэр угаа нэмэлт төсвөр зарласан. Проценурын хуудс бүрэн биелсэн боловч төсвөрүүд ажилгүй болсон боловч төсвөрийн ажил хийгдсэн тул 70% гүйцэтгэлтэй гэж үзэвч энэ ажил нь нийт ажлын 40%-ыг хангаварх тул 40-ийн 70 хууь нь = 28%

3. Зургааны ажлын гүйцэтгэл: Санхүүжилт хосалдсанээр бодит зургааны ажил хийгддэггүй 0%

Минд 30% + 28% + 0% = 58%

Гүйцэтгэлийг тооцоолох 1 хэсэг болгон тус бүрд аргаарх онцгой өгнө.

1. Ажлын даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьсан 25 оноо, бүрэн туй 100%

2. Ажлын даалгаврын гүйцэтгэлийг тооцсон 20 оноо, бүрэн туй 100%

3. Судалгааны ажлын тайланг боловсруулж дүгсэн 30 оноо, бүрэн туй 100%

4. Усны нөөцийн зөвлөмжөөр хэрэгжүүлж хэрэгжүүлэх 25 оноо, бүрэн хэрэгжүүлэх туй 80%

Минд 25 + 20 + 30 + 20 = 95%